ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2025. 02. 25 № 02/137

танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАЯРТУЯА ТАНАА

Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт . . . хуудастай.

ДЭД ДАРГА Ч.БОЛД

1117145633
УХА0612 9077278

02024310

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.BHDAIDG.A8.docx

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК
65-р байр 1 тоот, Бумцэндийн гудамж,
6-р хороо, 6-р хороолол,
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
И-мэйл: auditulziit@outlook.com
Утас: 70130460, 99109702, 88117655

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА ТАНАА

2025.03.11 № 25-41

танай_____-ны №_____т

Тайлан хүргүүлэх тухай

Манай байгууллага нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж санхүүгийн аудитын тайланг хүргүүлж байна.

2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг төлөвлөн, хуваарь гарган баталж 2025 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан тоотоор бидэнд ирүүлнэ үү.

Нийслэл дэх төрийн аудитын газрын 2025 оны 02 дугаар сарын 25-ны 02/137 тоот албан бичгийн хамт хүлээлгэн өгөв.

Хавсралт 1 хуудастай.

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК УЛААНБААТАР ХОТ 9024091599 № 5490677

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/283/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас:315558 Цахим хаяг:tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Өлзийт Экаунт Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Ч.Эрдэнэжав
Утас: 88117655 Цахим хаяг: auditulziit@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэл....4
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....14
4. АУДИТЫН ТАЙЛАН....16
4.1 Ерөнхий зүйл....16
4.2 Материаллаг байдал....16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа , ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЗ	Төрийн захиргааны
ТҮ	Төрийн үйлчилгээний
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/171
танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Б.БАЯРТУЯА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2024 оноос Нийгмийн даатгалын хуулийн шинэчлэсэн найруулагыг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн sicos систем бүрэн шинэчлэгдэж, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн систем portal.ndaaatgal.mn болж өөрчлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Нийгмийн даатгалын хэлтэс нь газар болон өөрчлөгдөж, нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланг тусад нь тайлагнаж, толилуулдаг болсон.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын газар нь 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.8 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**11,218,472.00**	**12,008,372.00**
35	**БАРАА МАТЕРИАЛ**	**11,218,472.00**	**12,008,372.00**
354	**Хангамжийн материал**	**11,218,472.00**	**12,008,372.00**
35410	Бичиг хэргийн материал	1,771,490.00	1,322,590.00
35420	Аж ахуйн материал	9,252,900.00	1,954,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	4,903,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	3,750,000.00
35470	Бусад хангамжийн материал	194,082.0	78,382.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**62,789,653.37**	**69,296,264.76**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**62,789,653.37**	**69,296,264.76**
392	**Биет хөрөнгө**	**62,789,653.37**	**69,296,264.76**
39201	Барилга, байгууламж, орон сууц	43,414,970.00	43,414,970.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,168,448.72)	(6,288,279.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,430,000.00	8,430,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,372,000.00)	(5,198,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,831,152.58	43,962,202.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,495,287.79)	(17,979,112.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,998,000.00	20,305,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,848,732.70)	(17,350.015.89)
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**74,008,125.37**	**81,304,636.76**
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН**	**74,008,125.37**	**81,304,636.76**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**74,008,125.37**	**81,304,636.76**
511	**Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/**	**58,450,614.99**	**58,450,614.99**
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	58,450,614.99	58,450,614.99
512	**Хуримтлагдсан үр дүн**	**15,557,510.38**	**22,854,021.77**
51210	Өмнөх үеийн үр дүн	15,557,510.38	15,557,510.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,296,511.39
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**74,008,125.37**	**81,304,636.76**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**261,303,664.00**	**306,817,550.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**1,542,964.00**	**2,749,550.00**
120	**Нийтлэгтатварын бус орлого**	**1,542,964.00**	**2,749,550.00**
1200	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	**1,542,964.00**	**2,749,550.00**
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,542,964.00	2,317,950.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал	-	431,600.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**259,760,700.00**	**304,068,000.00**
1310	**Төсвийн захирагчдаас**	**702,200.00**	**304,068,000.00**
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	304,068,000.00
1330	**Төвлөрүүлэх шилжүүлэг**	**702,200.00**	-
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	**259,058,500.00**	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	259,058,500.00	-
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**261,599,658.51**	**299,521,038.61**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**261,599,658.51**	**299,521,038.61**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**195,994,839.27**	**275,247,163.22**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**105,618,089.48**	**198,986,405.64**
210101	Үндсэн цалин	65,147,336.13	109,700,881.39
210102	Нэмэгдэл	19,652,961.35	48,167,442,14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,984,000.00	21,360,894.20
210104	Урамшуулал	9,833,792.00	19,757,187.91
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**13,414,781.30**	**23,293,277,52**
210201	Тэтгэврийн даатгал	9,410,676.06	15,976,231.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,101,575.26	1,923.066.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	832,442.21	958,233.07
210204	Ажилгүйдлийн даатгал	188,189.87	887,129.37
210205	Эрүүл мэндийн даатгал	1,881,897.90	3,548,617.40
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**2,932,217.72**	**4,077,426.79**
210301	Гэрэл, цахилгаан	795,369.72	1,250,535.79
210302	Түлш, халаалт	1,808,450.00	1,870,500.00
210303	Цэвэр, бохир ус	328,398.00	501,391.00
210304	Байрны түрээс	-	455,000.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**4,906,073.26**	**20,533,070.66**
210401	Бичиг хэргийн материал	2,363,805.00	7,586,200.00
210402	Тээвэр, шатахууны зардал	984,800.00	1,648,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	183,872.26	457,970.66
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	304,896.00	507,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	937,500.00	10,208,500.00
210408	Бараа материал акталсны зардал	131,200.00	124,300.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**53,722,000.00**	**10,424,200.00**
210601	Багаж, техник, хэрэгсэл	937,000.00	674,200.00
210604	Урсгал засвар	52,785,000.00	9,750,000.00
2107	**Томилолт, зочны зардал**	**248,950.00**	**450,000.00**

210702	Дотоод албан томилолт	248,950.00	450,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж**	**4,300,600.00**	**5,596,444.00**
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	4,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	189,100.00	490,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,984.00	59,984.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	36,960.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	29,516.00	9,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**10,852,127.51**	**11,886,338.61**
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	475,000.00	319,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,377,127.51	11,567,338.61
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**65,604,819.24**	**24,273,875.39**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**32,219,700.00**	**13,720,375.00**
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,778,000.00	2,440,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,441,700.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	11,280,375.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**-**	**10,553,500.39**
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	10,553,500.39
2135	**Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**33,385,119.24**	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,385,119.24	
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)**	**(295,994.51)**	**7,296,511.39**
6	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**(295,994.51)**	**7,296,511.39**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	**2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**58,450,614.99**	**15,853,504.89**	**74,304,119.88**
C03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**58,450,614.99**	**15,853,504.89**	**74,304,119.88**
C07	Тайлант үеийн үр дүн/ Цэвэр ашиг алдагдал/	-	(295,994.51)	(295,994.51)
C08	**2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**58,450,614.99**	**15,557,510.38**	**74,008,125.37**
D01	**2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**58,450,614.99**	**15,557,510.38**	**74,008,125.37**
D03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**58,450,614.99**	**15,557,510.38**	**74,008,125.37**
D08	Тайлант үеийн үр дүн/ Цэвэр ашиг алдагдал/		7,296,511.39	7,296,511.39
D09	**2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**58,450,614.99**	**22,854,021.77**	**81,304,636.76**

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН**	**272,683,093.60**	**304,068,000.00**
12	**ТАТВАРЫН БУСОРЛОГО**	**13,624,593.60**	**-**
120	**Нийтлэгтатварын бус орлого**	**13,624,593.60**	**-**
120009	Бусад орлого	13,624,593.60	-
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**259,058,500.00**	**304,068,000.00**
1310	**Төсвийн захирагчдаас**	**-**	**304,068,000.00**
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	304,068,000.00
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	**259,058,500.00**	**-**
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	259,058,500.00	
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**272,683,093.60**	**288,312,000.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**272,683,093.60**	**288,312,000.00**
210	**БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**207,078,274.36**	**264,038,124.61**
2101	**Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил**	**105,618,089.48**	**198,986,405.64**
210101	Үндсэн цалин	65,147,336.13	109,700,881.39
210102	Нэмэгдэл	19,652,961.35	48,167,442,14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,984,000.00	21,360,894.20
210104	Урамшуулал	9,833,792.00	19,757,187.91
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**13,414,781.30**	**23,293,277,52**
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	9,410,676.06	15,976,231.58
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,101,575.26	1,923,066.10
210203	ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	832,442.21	958,233.07
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	188,189.87	887,129.37
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,881,897.90	3,548,617.40
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**2,932,217.72**	**4,077,426.79**
210301	Гэрэл, цахилгааны зардал	795,369.72	1,250,535.79
210302	Түлш, халаалтын зардал	1,808,450.00	1,870,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	328,398.00	501,391.00
210304	Байрны түрээс	-	455,000.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**12,771,558.26**	**12,661,370.66**
210401	Бичиг хэрэг	3,348,490.00	7,137,300.00
210402	Тээвэр, шатахуун	984,800.00	1,648,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	183,872,26	457,970.66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	304,896,00	507,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,949,500.00	2,910,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**53,722,000.00**	**18,663,200.00**
210601	Багаж, техник, хэрэгсэл	937,000.00	5,163,200.00
210604	Урсгал засвар	52,785,000.00	13,500,000.00
2107	**Томилолт, зочны зардал**	**248,950.00**	**450,000.00**
210702	Дотоод албан томилолт	248,950.00	450,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**4,271,084.00**	**5,587,444.00**
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	189,100.00	490,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,984.00	59,984.00

210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	36,960.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**14,099,593.60**	**319,000.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,624,593.60	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	475,000.00	319,000.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**65,604,819.24**	**24,273,875.39**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**32,219,700.00**	**13,720,375.00**
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,778,000.00	2,440,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,441,700.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	11,280,375.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	-	**10,553,500.39**
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	10,553,500.39
2135	**Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**33,385,119.24**	**-**
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,385,119.24	
3	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	-	**15,756,000.00**
5	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ**	-	**15,756,000.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	-	**15,756,000.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	-	**15,756,000.00**
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	15,756,000.00
6	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	-	**(15,756,000.00)**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН**	**304,068,000.00**	**293,514,499.61**	**10,553,500.39**	**96.5**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**304,068,000.00**	**293,514,499.61**	**10,553,500.39**	**96.5**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**290,296,900.00**	**279,794,124.61**	**10,502,775.39**	**96.4**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**202,203,300.00**	**198,986,405.64**	**3,631,897.87**	**98.2**
210101	Үндсэн цалин	100,861,900.00	109,700,881.39	(8,838,981.39)	108.8
210102	Нэмэгдэл	55,521,500.00	48,167,442,14	7,354,057.86	86.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,343,600.00	21,360,894.20	7,982,705.80	72.8
210104	Урамшуулал	16,476,300.00	19,757,187.91	(3,280,887.91)	119.9
2102	**Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл**	**25,275,400.00**	**23,293,277,52**	**1,567,118.97**	**93.8**
210201	Тэтгэврийн даатгал	17,187,300.00	15,976,231,58	796,064.91	95.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,022,000.00	1,923,066.10	98,933.90	95.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,011,000.00	958,233.07	52,766.93	94.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,011,000.00	887,129.37	123,870.63	87.7
210205	Эрүүл мэндийн даатгал	4,044,100.00	3,548,617.40	495,482.60	87.7
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**4,202,800.00**	**4,077,426.79**	**125,373.21**	**97.0**
210301	Гэрэл цахилгаан	1,203,200.00	1,250,535.79	(47,335.79)	103.9
210302	Түлш, халаалт	1,911,600.00	1,870,500.00	41,100.00	97.8
210303	Цэвэр, бохир ус	633,000.00	501,391.00	131.609.00	79.2
210304	Байрны түрээс	455,000.00	455,000.00	-	100.0
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**12,703,300.00**	**12,661,370.66**	**41,929.34**	**20.9**
210401	Бичиг хэрэг	7,137,300.00	7,137,300.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун/	1,648,500.00	1,648,500.00	-	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	491,500.00	457,970.66	33,529.34	93.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	516,000.00	507,600.00	8,400.00	98.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	2,910,000.00	2,910,000.00	-	100.0
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**34,419,200.00**	**34,419,200.00**	**-**	**100.0**
210601	Багаж, техник хэрэгсэл	20,919,200.00	20,919,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	13,500,000.00	13,500,000.00	-	100.0
2107	**Томилолт, зочны зардал**	**480,000.00**	**450,000.00**	**30,000.00**	**93.7**
210702	Дотоод албан томилолт	480,000.00	450,000.00	30,000.00	93.7
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**10,546,900.00**	**5,587,444.00**	**4,959,456.00**	**52.9**
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,810,000.00	5,000,000.00	4,810,000.00	50.9

210803	Даатгалын үйлчилгээ	490,500.00	490,000.00	-	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	59,984.00	16.00	99.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	186,400.00	36,960.00	149,440.00	19.8
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**466,000.00**	**319,000.00**	**147,000.00**	**68.4**
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	466,000.00	319,000.00	147,000.00	68.4
213	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**13,771,100.00**	**13,720,375.00**	**50,725.00**	**99.6**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**13,771,100.00**	**13,720,375.00**	**50,725.00**	**99.6**
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,490,500.00	2,440,000.00	50,500.00	97.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,280,600.00	11,280,375.00	225.00	100.0
12	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**304,068,000.00**	**293,514,499.61**	**10,553,500.39**	**96.5**
1310	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**304,068,000.00**	**293,514,499.61**	**10,553,500.39**	**96.5**
131001	Улсын төсвөөс санхүүжих	304,068,000.00	293,514,499.61	10,553,500.39	96.5
6	**ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ**	**13.00**	**13.00**	**-**	**100.0**
61	**БАЙГУУЛЛАГЫН ТОО**	**1.00**	**1.00**	**-**	**100.0**
61001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	**АЖИЛЛАГСДЫН ТОО**	**6.00**	**6.00**	**-**	**100.0**
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.0
65	**ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ**	**6.00**	**6.00**	**-**	**100.0**
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5.00	5.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуулиар тогтоосон хугацаанд олгох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Нийслэлийн Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газар нь "даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх" гэсэн эрхэм зорилготойгоор Нийгмийн даатгалын тухай багц хууль, Эрүүл мэндийн даатгалын хуулийн шинэчилсэн найруулга, Улсын их хурал, Засгийн газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагаа болон Нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтийг ханган иргэд даатгуулагч, ажил олгогчийн хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, сангаас даатгуулагчдад нийгмийн даатгалын бүтээгдэхүүн түргэн шуурхай үзүүлэх 4 зорилт 46 арга хэмжээ хэрэгжүүлж 93.8 хувьтай гэж дүгнүүлсэн байна.

Тус газар нь дотоод нэгжгүй, батлагдсан 6 хүний бүтэц, орон тоотой ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль;
- ТБОНӨХБАҮХАТ хууль шинэчлэн найруулагдсан;
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан;
- "Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандарт" батлах тухай /2024 оны 1-р сарын 19-ний өдрийн А/19 дугаар тушаалаар баталж мөрдөж эхэлсэн/;
- ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай";
- ЗГ-ын 2024 оны 2 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай".

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, ажилтан байхгүй бөгөөд тайлант онд НДЕГ-аас 2024 онд ҮОМШӨ даатгалын санд, Дотоод аудитын газар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар зөрчилтэй асуудал гараагүй байна.

Тус газар нь НДЕГ-аас баталсан орлого зарлагын хуваарийн дагуу зарцуулах, сар бүрийн нэгний өдөр орлого зарлагын сарын мэдээ гарган шалгуурыг ханган ажилласан

байна. НДЕГ-аас сар бүр үйл ажиллагааны санхүүжилт, тэтгэвэр тэтгэмжийн сангийн санхүүжилтийг авдаг бөгөөд сар бүр төсвийн гүйцэтгэлийн зардлын мэдээ, улирал бүр санхүүгийн тайланг тайлагнаж хянуулдаг.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

НДЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын А.64 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газар 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,296.6 мянган төгрөгөөр буюу 10.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	11,218.5	12,008.4	789.9
Үндсэн хөрөнгө	62,789.6	69,296.2	6,506.6
Нийт хөрөнгө	**74,008.1**	**81,304.6**	**7,296.5**
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	74,008.1	81,304.6	7,296.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**74,008.1**	**81,304.6**	**7,296.5**

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмч данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,008.4 мянган төгрөг болж 789.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 30,359.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 431.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 30,000.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 69,296.2 мянган төгрөг болж 6,506.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 15,756.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 2,317.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авсан өсөлт болон тайлант онд 4,635.9 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 6,931.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 7,296.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 304,068.0 мянган төгрөг, нийт зарлагыг 304,068.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 304,068.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 202,203.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 25,275.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,202.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 12,703.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 34,419.2 мянган төгрөг, томилолт, зочны зардал 480.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 10,546.9 мянган төгрөг, бусад зардал 466.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 13,771.1 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг эдийн засгийн ангиллаар 304,068.0 мянган төгрөгийн зардлыг улсын төсвийн орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 304,068.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 293,514.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 10,553.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 293,514.5 мянган төгрөг буюу 96.5 хувь зарцуулж ажилласан байна. Үүнд: цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 198,571.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардал 23,708.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,077.4 мянган төгрөг, хангамж,

бараа материалын зардал 12,661.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 34,419.2 мянган төгрөг, томилолт, зочны зардал 450.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 5,587.4 мянган төгрөг, бусад зардал 319.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 13,720.4 мянган төгрөгийн тус тус зардалд зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71901- Нийгмийн даатгал		**304,068.0**	**293,514.5**	**10,553.5**	**96.5%**
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	286,083.8	275,581.0	10,502.8	96.4%
2	80224-Зөвлөл, хороо	2,263.1	2,263.1	0.0	100.0%
3	80820-Бусад тусламж, дэмжлэг	1,950.0	1,950.0	0.0	100.0%
4	80820-Бусад урсгал шилжүүлэг	13,771.1	13,720.4	50.7	99.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайланг гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газар нь тайлант онд урсгал үйл ажиллагааны төсвөөс 30,359.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс шууд худалдан авалтын аргаар 2,910.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 13,500.0 мянган төгрөгийн барилгын засварын материал, 6,811.7 мянган төгрөгийн сэлбэг, хэрэгсэл, түлш, шатах тослох материал, 7,137.3 мянган төгрөгийн бичиг хэрэг бусад хангамжийн материалын худалдан авалтыг 16 аж ахуйн нэгжтэй хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлан гаргалт, ур чадварын нэмэгдэл олгохдоо батлагдсан журмын дагуу үнэлж олгох, худалдан авалттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өлзийт Экаунт Аудит ХХК-ийн аудитор Ч.Эрдэнэжав, аудитын менежер Д.Мандахбаяр нар гүйцэтгэж, хяналтыг чанарын удирдлагын менежер Ц.Бямбажав, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өлзийт экаунт аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсөв, суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн нийт зардлын 304,068.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,561.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэж цалин хөлсийг ажлын гүйцэтгэлээр олгож ажилласан байна.
Тайлант онд албан хэрэгцээнд 46,115.0 мянган төгрөгийн нөүтбүүк, принтер, тавилга бусад зүйлийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, нэр бүхий 20 аж ахуйн нэгжээс шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 46,115.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 444,079.7 мянган төгрөгийн 32 мэдээллийг байршуулахаас 444,079.7 мянган төгрөгийн 32 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn системд ил тодоор мэдээлээгүй байна.

Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 15,763.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг гүйцэтгэлийн шатанд давтан тооцоолж үзэхэд залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 217,011.9 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 208,461.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 8,550.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	208,461.7	3	208,461.7	100.0
Зөвлөмж	2	8,550.2	2	8,550.2	100.0
Нийт дүн	5	217,011.9	5	217,011.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц дараах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 15,763.2 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулга хийлгэлээ.

Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 15,436.7 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон;
- Цалингийн зардал, даатгуулагчийн НДШ-ийг нийт 326.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолсон	1	15,436.7			1	15,436.7	1	15,436.7				
Цалингийн зардал, даатгуулагчийн НДШ-ийг зөрүүтэй илэрхийлсэн байна.	1	326.5			1	326.5	1	326.5				
Нийт	**2**	15,763.2			**2**	15,763.2	**2**	15,763.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн
Тайлант хугацаанд албан хэрэгцээнд 46.1 мян.төгрөгийн нөүтбүүк, принтер, тавилга бусад зүйлийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авсан байна.	1	46,115.0					1	46,115.0
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn-д ил тодоор мэдээлээгүй байна.	1	0.00					1	0.00
Нийт дүн	**2**	**46,115.0**					**1**	**46,115.0**

Утас: +976 70007734
Факс: +976 70007734

Цахим шуудан: ub@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Нийслэлийн өмчийн нэгдүгээр байр,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар
дүүрэг Улаанбаатар-15160, Монгол Улс